



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 9/08

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дугаар зүйлийн 109.4 дөх заалт, Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүх нийтийн амралтын өдрүүд буюу 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 06-ны өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүрийн нэрсийг нэгдүгээр хавсралтаар, хариуцлагатай эргүүлээр ажиллах хугацаанд дагаж мөрдөх ажлын зааварчилгааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Амралтын өдрүүдэд гар утсаа нээлттэй байлгаж хариуцлагатай жижүүрийг чанартай гүйцэтгэж ажиллахыг хэлтсийн дарга нарт, батлагдсан хуваарийн дагуу хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэж ажилласан хугацааныхаа рапортыг бичиж, дараагийн жижүүрт хүлээлгэн өгч ажиллахыг жижүүрээр томилогдсон ажилтнуудад тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга /Л. Эрдэнэбат/-д даалгасугай

ДАРГА



Ч.РЭГЗМАА

3150600603

“Хот төлөвлөлт, судалгааны институт”
ОНӨААТҮГ-ын даргын 2022 оны 02 дугаар
сарын 01 ны өдрийн тушаалын хавсралт



ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛЭЭР АЖИЛЛАХ ХУГАЦААНД ДАГАЖ МӨРДӨХ АЖЛЫН ЗААВАРЧИЛГАА

1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд тэдгээрийг тэмдэглэн өнгөрүүлэх болон хариуцлагатай эргүүл ажиллуулахтай холбоотой холбогдох тогтоол шийдвэр, зааварчилгааг судалж танилцсан байх
2. Нутгийн захиргааны байгууллагын дотоод журамтай танилцаж, ажил үүргээ гүйцэтгэхдээ дагаж мөрдөх
3. Рапортын дэвтэрт зааварчилгааны дагуу рапорт хөтлөх
4. Хариуцлагатай эргүүлүүд ээлж солилцохдоо ажлаа хүлээлцэн, гарын үсэг зурах
5. Сар шинийн баяр буюу шинийн 1,2,3,4,5-ны өдрүүдэд /2022.02.02-наас 2022.02.06 дуустал/ гар утсаа салгахгүй байнгын нээлттэй байлган дуудсан тохиолдолд бэлэн байх
6. Гар утас эвдэрсэн болон холбогдох боломжгүй болсон тохиолдолд хариуцсан хэлтсийн даргад болон хүний нөөцийн мэргэжилтэнд урьдчилан мэдэгдэх
7. Хариуцлагатай эргүүлүүд сар шинийн өдрүүдэд хөдөө орон нутагт зорчихгүй байх
8. Ажил үүргээ гүйцэтгэх хугацаандаа болзошгүй аюул, аваар ослын талаар нэн даруй мэдээлэх байгууллагын холбогдох албан тушаалтнууд болон Нийслэлийн ерөнхий эргүүл, Хариуцлагатай жижүүрт мэдэгдэх
9. Хариуцлагатай эргүүлээр ажиллах явцдаа бусдаас зай барих, олон хүн цугларсан газарт очихгүй, байнгын амны хаалт зүүж гараа тогтмол ариутгаж байх
10. Хувийн аюулгүй байдлыг хангаж, орой үдэш гэр лүүгээ явахдаа болгоомжтой тээврийн хэрэгслийг сонгож, үйлчлүүлэх
11. Согтууруулах ундааны зүйл хэрэглэхгүй байх